

ЗАЯА, ЗАЯА НИЙТГЭСЭН ГЭГЭЭН АЯЛГУУ

Нэг

Найраг баян хуур хөгжимд " Манжуурын толгод" намуухан радиогоор эгшиглэж бид хоёр ярилцан ууна.

- Жамсран гуай ер нь хүртээмжтэй ажилладаг дарга байлаа. Би нэг удаа Дэлгэрхаанд томилолтоор явж ирээд гүйцэтгэл танилцуулж дуустал орсон айлуудын маань ам бүл нь хэд, хэдэн төгрөгний хөлс авдаг, өвчтэй зовлонтой хүн гээд шалгасан албан газрын нарийн ширийн юм шалгааж мохоогоод хувийн зардлаар хоёр удаа буцааж билээ. Анхандаа мөн ч ундууцсансан.

Сумбайгууллагад томилолтоор ажиллавал бүхнийг мэдэж, үзэж зөлөж ирнэ. Надад сургууль пхдгүй гээд л орхивол хэрэг бишдэнэ. Би өвөл хөдөөнөөс шуудангаар 23 цагт ирээд 24 цагт Жамсран гуайд ажлаа танилцуулж ч явсан. Цаг хугацаатай үүрэг өгдөг, хэлсэндээ шалгадаг хүнсэн. Тэр ямарч том судалгаа тоо бариад ороход өөрөө сампиндаж шалгана шүү дээ. Шаардлаганд нь тэнцэх гэж бид маш цэвэр гоё шугамдаж бичиж заншсансан.

Аймгийн захиргааныхан хөдөө томилолтоор ажиллана гэхээс их л бэргэнэ. Жамсран гуай аймгийнхаа маш олон айлын амьдралыг сайн мэдэх болохоор худлаа хэлэх арга байхгүй. Биднийг гарын ая дааж ажилд дөртэй болоод ирэхэд эцгийн ёсоор баярлана. Шаардалагатай, хамаламжтай даргын ачаар би амьдрал таньсан хүн гэлээ. Хорин гурван жил статистикийн албанд зүтгэчихээд өнөөдөр өөрийнх нь тухай асуухлаар хүний тухай яриад байдаг. Хөгийн юм шүү.

ХЭЛЭН ДЭЭР НЬ ЯМАР УТГА БИЧСЭН БОЛ?

Баянчулуутад Сүхийнхийг шинэ нутагт ханаа шийрлэж униа өлгөхөд намрын тосон жаргал наран тооныг нь мялаан өндийж саахалт айлын яндангаар утсан чинээ цэнхэр утаа угалзраа. Малчин Сүх энэ дөрөвдүгээр багаар барахгүй Авдарбаяндаа зартай нямбай ажилсаг хүн. Тэр жил эдний хоноь нь мянгад дөхжээ. Барга нутгийн алдартай буянаа арвижуулахсан гэж Сүх жил бүр ууган хурга майлахад эхнийнх нь хөхний бөглөөг гаргаж хөндлөнгийн гай түүтгэр, ган зуд, өвчин эмгэг, чонон нохой, хулгай, худал, алба гувчуурын аюулгүй, хурга төл, идээ цагаа эл бэг, аргал түлш арвин, нас урт хүчин төгс, энх тунхын билэг санаж буух нутаг, уух ус, суусан учирсан, газар тэнгэр- ус салхи, хол ойрын улс гүрэн лус эздийг аргадан шинэ цагаан идээнийхээ дээжийг тэр бүхнээ зориулан хонины сацал өргөж сан даллага болно.

Шинэ нутаг буусны хойт өдөр эхнэр Батсүх нярайлж хөөрхөн хар толгойтой нуган хүү төржээ. Цаг төрийн үймээний хөлөөр 1920-иод онд Хөлөн бөөрөөс хөдөлсөн баргын их нүүдлийн нэг ахлагч Жамбал гүн бээр бяцхан ачийг ухаах өдрийг тэсэн хүлээв. Богдоос нутаг заалгаж төвхнөөд энэ Авдархангайд баргын хүн мал өсч, өрх голомт өнөржсөнд тэр өтгөс сэтгэл тэнүүн сууна.

Дэлхийн дайн дажин, пролетарийн соёлын хувьсгал уухиа буухиа явдалд сүшиг заншлаа алдаруулахаас аргагүйд тулсан тэр цагт Жамбал гүн өчүүхэн хүүд энх амгалан өнө амьдралын билэг бодож Амарбат хэмжээх нэр хайрлажөвгөдийн заншил ёсоор нялх, хүүгийн хэлэн дээр эрдэнийн үсэг бичиж ёсловой.

Төр төрийн хөлд нөөлөглөх их салхинаас залхсан нүүдэлчин баргын өвгөн түшээ, ач хүүдээ нэр хайрлахдаа юу бодсон нь тодорхой ч хэлэн дээр нь бичсэн эрдэнийн гэрэлт үсгээр юу юу билэгдснийг хэн мэдлээ. Хүний сэтгэлийн бясалгал хайрын хайлан гэж ээ дээ мөн чиг. . .

Энэ бол 1941 оны адал явдал асанжээ.

- Манай статистикийн хэлтсийн дарга Нацагдорж болохоор тунчиг няхуур чамбай, хатуу шаардлагатай. Тэр нь өмнөх дарга Ө. Хаянхярваа гуайн арга л даа.

Хэний маань ч хийсэн ямар ч мэдээ судалгаа Нацагдоржийн хяналт, зөвшөөрөлгүй, хаана ч өгөгдөхгүй. Бүгдийг эх материалтай тулган бодож шалгана. Ганц тоо зөрүүлвэл жилийнхээ ажлын үнэлгээг авлаа гэсэн үг.

Миний багш Д.Аюуш, Ц.Бямбаа даа.

Аймаг сум аль ч байгууллага статистикийн товчооны тоог л чин үнэнд барьж ажлаа явуулж үнэлж дүгнэж, шагнаж зэмлэж ирсэн юм. Үнэндээ ч үнэн тоо нь энд байсан.

Нацагдорж дарга бидэнд бие биеийнхээ ажлыг саадгүй орлон гүйцэтгэх чадвар эзэмшүүлсэн. Хэний сейфенд ямар тоо хаанаа байгааг бид андахгүй, эзгүй нэгийгээ хэн нь ч орлоно. Юм маш эмх цэгцтэй. Энэ хатуу заншил биднийг жинхэнэ мэргэжилтэн болгоод зогсоогүй сумдын дарга мэргэжилтнүүдийг ч чадварлаг ажилтан болоход нөлөөлсөн юм даа.

Найраг Баянхуур эгшиглэнэ. . .

Хоёр.

Сэтгэлийн тэр нэгэн амраг эргэж ирэхгүй... 1967 он. Батхаан уул ногооны униарт умбаж Цант, Цахир, Мөөрсийн голоор ангир явгалан тун ч гоё зун болж Эрдэнэсантын МААМС-ынхан хадландаа зэхэж морин хадуур сэлтээ ирлэцгээж байлаа.

Бас ч хэдэн жил ажилласан болоод юу нь болохоо больсныг мэдэхгүй, хадуур, тармуур нилээдийг нутагт гээдгийн даваан дээр инжнертэй золгожээ.

Амарбат гэж хөөрхөн хар нүдтэй, яралзсан цагаан шүдтэй намхан бор хүү ХААДС төгсөөд хоёр хүүхэдтэй оюутан эхнэрээ дагуулчихсан ангир шиг амьтад хүрээд ирсэн нь хөдөө нутагт жавхаа нэмжээ. Инженер шиг гар бөмбөг тоглохсон, инженерээр баянхуур заалгана гэж хөл болцгооно. Бүжиг заалгаж хөгжилдөнө.

- Эхнэр нь гэж сайхан амьтан
- Манай сум ч удахгүй хүний их эмчтэй болно.
- Ээ дээ Мөнхнасан ч мундаг сурдаг гэнэлээ. Аймаг хотын эмнэлэг аваад явчихана биз.

Сэтгэл догдолсон ийм яриа өрнөнө.

Баргын Жамбал гүн хэлэн дээр нь номын үсэг шившсэн өнөө хүү Өвөр Шавартай дахь Авдарбаян сумын төвд дөрвөн гэртэй бага сургуульд хөх даалимбан тэрлэгтэй дэрвэн ирж Балжир багшаараа А-гийн ацаг зурах гарынхаа ээдрээг гаргуулж явсныг бодоход одоо эрдмийн мөр нэгэн далайд аялаад инженерийн багаж атгасаар нөгөө эрэгт буусан нь тэр байлаа.

Эрэг, шураг, ремень мотортоо ч эмнэг сургагч юмаа гэгцгээнэ.

Залуугийн цагт хийж чадаж, хэлүүлж магтуулж явах бас сайхан.!

Оргилж цоргилж явахад орчлон хөрвөх гэж айхавтар юм байдаг. Амарбатыг тийм тавилан эргүүлэндээ гэнэт хамах нь тэр!

Гэгээн өдрийн нар унах шиг тийм тохиолыг бичих гэж юу байхав. Би шүлгээ хайлъя.

Хайлан уйлж би чамайгаа хайж явах юм

Хасарвааны мод цэцэглэх яагаа ч үгүй байх юм

Дэрээ тэмтрээд би чамайгаа эрээд байх юм

Дэвэн ганганаад шувууд ирээд байх юм

Хоног хоногийн эргэлтэнд саран тураад байх юм

Хоолой давахгүй дуунд минь санчиг хяруулаад байх юм

Хоосон чанрын замбуулинд намайгаа үлдээчих байсийм бол

Хорвоон уртрагт учирч энхрийлж яахнаа нь хайрласийм бэ

Зүүний сүвэгч сэтрэх шиг хүний амь гэдэг нь

Зүүдний диваажинд юм шиг амьдрал ахархан гэдэг нь

Аялгуу хангинуулж аргадавч алган дээр од буухгүй

Агар зандан навчлавч амраг чи минь ирэхгүй

Хайлан уйлавч би чамайгаа хэзээ ч олохгүй

Харагдах болгоноос горьдож хайхгүй байж ч чадахгүй ээ !

Гурав

Амарбатын хуруу цахим тооцоолуурын товч дээр сурмаг баян хуурчийн дадмаг солилтоор гүйхэд тооных нь гэрэл эгшиглэх шиг санагдана.

- Намайг Статистикийн улсын байцаагчаар олон жил ажиллуулсан. Урт богино хугацааны мэдээ судалгааны үнэн мөн нь жилийн эцсийн мал тооллогын дүн, бас балансаар шалгагдчихана шүү дээ.

- Гурван багана тоо зэрэгцүүлээд харахад чинь хэн яаж мэдээ тоонд хандсан нь илхэн. Манай статистикт 1969 он хүртэл сумдаас мэдээгээ тусгай маягтаар гаргуулж шуудангаар авдагсан. Тэгэхэд би шөнө холбоонд ирсэн шуудан тосч мэдээгээ аваад үүр цайтал сууж нэгтгээд өглөө дарга нарт шалгуулна. 1970 оноос мэдээг шиферт оруулж утсаар авдаг болсон юм. Утсаар хоолойгоо сөөтөл өдөржин хашгираад шөнө нь сууж нэгтгэнэ дээ. Аймгийн хурал, чуулган, зөвлөлгөөний өмнө тоо авах гэж мөн ч их бажигдана. Ажилласан 23 жил маань ийн өнгөрлөө гээд цонх руу харлаа. Статистикч Амарбат бол монголд анх мал тооллогын А дансны мэдээг тооцоолон бодох машинд оруулалцсан мэргэжилтэн юм. Тэгээд ч 18 аймгаас малын тоо тушаахад айргын таваас арагшилж үзсэнгүй.

Миний ажиллах хугацаанд манай статистикийн товчоо улсад 1-5-р байрт тогтмол шалгарч байлаа. Нямбай, чамбай дарга нарын маань ач шүү дээ. Ажил сайн болохоор бид чинь цалингийн 70 хувь хүртэл шагнуулна.

Дөрөв

Харийн газар эрдэм сурахаар

Орос баатрын дуулга малгай мэт бөмбөгөр оройт сүм,нараад дэлгэрсэн орчин цагийн барилгууд жагссан эртний ногоон хот Киевт ирээд Амарбат жилийн нүүр үзэж агийн цэнхэр униарт Авдарын хөх уулсаа санагалзаж ард үлдсэн үр хүүхдийн царай амраг Чийчигмаагийнх нь янзаган хар нүд зүүдэнд тодроход бас ч яарна.

Тэр жил Алма-Атад 45 хоноход шинэдээд гэрээ илүү их санаж билээ. Финлянд, Уганд, Иран, Ирак, Пакистан, Кипр чухам есөн хэлийн хүмүүстэй жил болоход аргачилал, хууль нь адилхан юм болохоор тоо томъёогоор, статистикч гэсэн нийтлэг мэргэжлээрээ ойлголцож явлаа. Аль ч улс гүрэн бүртгэл зүйг амин чухал хэрэгцээгээ болгон хөгжүүлдэгийг энд илүү тод мэдрэв.

Амарбат Төв аймгийнхаа 30-аад нэгжээс өдөржин утасдаж мэдээгээ цуглуулаад үүр байтал сууж дүнгий нь гаргадаг МАА, газар тариалан болоод хашаа худаг, тэжээл, техник, эмнээцлэг гээд ХАА-н туслах арга хэмжээний 10 хоног, сар, улирал, жилийн мэдээг хөгжилтэй орнууд тооцоолон бодох техникийн хүчээр бага цагт цуглуулж боловсруулдгийг мэдэв. Тэгээд ч Монголын бүртгэл зүйд тооцоолох техник нэвтрүүлэхэд суралцаж суугаагаа их завшаанд бодно. Ер нь инженер Амарбат статистикч болох юм чинээ хэн санахав. Уй гашуу тохиолдсон тэртээ 1969 онд гачигдлаа танилцуулж хүсэлт тавихад аймгийн дарга Жамсран Статистикийн товчоонд ХАА-н мэргэжилтэн гэдэг албанд тавьснаар ажил мэргэжлийг ч амьдралыг ч цоо шинээр эхлэхээс өөр аргагүй болжээ.

Баланс тооцоо барих нь байтугай сампинд ч гар хүрч үзээгүй түүнд тулгамдах, бухимдах, шахамдах зүйл өчнөөн тохиолдсоныг яахин тоочиж барах вэ?

Сайн нөхөд, сайхан дарга нарын нөмөр нөөлөгт өдий зэргийн статистикч болчихоод хилийн чанадад юм сураад харьж яваа гэхээс хурдан онгоцны суудлаас ухасхиймээр санагдан яарна. Энэ бол 1978 оны явдал бөгөөд НҮБ-ээс хийлгэсэн сургалтанд эх орноосоо гурвуул сураад харьж яваа нь тэр.

ТӨГСГӨЛ

Сая сурсан дуугаа охин нь дуулна.

Торомгор алаг нүд чинь ээ хө

Толгодын цаанаас тормолзоно

Тором шиг аргамжаатай бидэн хоёр
Томоогүй явдлаа дурсана даа
Сурсан дуугий нь эх нь чагнана
Аз тохиосон алаг нүдэн
Амьдрал хайрласан амин нүдэн...

Чийчигмаа гэж галав шалав хөдөлгөөнтэй урлагт цагтаа авъяасаа сорьж явсан нүдэнд дулаахан бор хүүхэнд заяа заяа нийтгэсэн амьдралынх нь олон явдал элэг төөнөөд нэг л уяралтай.

Зовлон жаргал үзсэн ханийнхаа санчигт харвасан цанг хараад үдэш бүрийтэл тоо шагайсан үйлий нь нимгэлж асаръя даа гэж уярна. Хүн эмгэлэгийн үнэр шингэсэн цагаан халаатыг нь нөхөр нь ямархан нямбай авч тавьдагт бас уярна.

Төөрөг заяаны тэнхлэг дээр гуниг баяр тээж Амарбатынх гэдэг айлын халуун голомт бадрааж өнчин хоёр хүүхдийг нь өөрийнх лүгээ ижий сэтгэлээр өсгөсөн ая буян энэ эхэд бий.

Манай Амарбатынхан удмаараа нямбай нэг барьснаа яс хийдэг махруу хүмүүс. Ах нь Дорж гэж Баян суманд хорин жил нярав хийхдээ улаан мөнгөний дутагдал гаргаагүй хүн бий. Борхүүгийн Алтангэрэл гэж эмчийг муу хэлэх хүн гарахгүй дээ. Сэтгэлээ өгсөн энэ л мэргэжилдээ үнэнч нөхөр маань Зуунмод сумын статистикч эдийн засагч гэдэг алба хашаад долоон ам бүлтэй өрх гэрээ өөд татаад амьдарч явна гэсэн юм. Амарбат 3 таван жилийн гавшгайч, бүртгэл статистикийн тэргүүний ажилтан хүн дээ. Энэ бүхнийг сонсож суухдаа би баргын Жамбал гүн бяцхан Амарбатын хэл дээр өнө урт амьдралын арга билэг шингээсэн тооны аялгуу зурсан юм биш байгаа даа гэж тааж бодов.

Ямар ч айтугай Амарбатын тоо нягталсан амьдрал нь заяа заяа нийтгэсэн гэгээн аялгуу болж хүмүүсийн хувь зохиолд уянгалсан юм баяна шүү дээ.

(Ш.Цэрэндоогийн "Амьдрал шинжсэн тоочид" номоос)